



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

### БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Осол, аюулгүй, эрүүл ажлын байрыг бий болгох
- Ажил эрхлэлт ба дэлхийн түвшний сургалтын боломжуудыг бий болгох
- Ажилчин авч ажиллуулахдаа орон нутаг буюу бүс нутгийн ажиллах хүчинд давуу тал олгох.

### ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Ажлын байран дээрх аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн боломжит эрсдэл
- Ажиллах хүч ихээр шаардлагатай барилгын ажлын үе шатанд ажлын байрыг шууд болон шууд бусаар бий болгож, улмаар барилгын ажил дуусаж, ашиглалтын үйл ажиллагаа эхэлсний дараагаар ажлын байрны тоо буурах.

### БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

#### АЖИЛЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ МЭНД:

- “Осол, аюулгүй ажлын байр”-ыг бий болгох
- Өөрийн ажиллах хүчний хамгийн дээд зэргийн хамгаалалтыг баталгаажуулахын тулд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны дэлхийн тэргүүлэх туршлагуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- Дэлхийн жишигт нийцэх аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар ажилчдын аюулгүй ажиллагааны шинэ хэм хэмжээг бий болгох
- Уурхай дээр ажиллаж буй ажилчин бүрт эрүүл мэндийн үзлэгт орох боломж олгох



- Бүх ажилчдын ажлын цагийг шударгаар тогтоон баталгаажуулах (жишээ нь гүний уурхайн ажилчид өдөрт 8 цаг ажиллаж, хоёр хоног тутамд нэг удаа 12 цаг амарч байх)
- Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг байнга тайлагнаж, стандартуудад нийцэж буй эсэхээ баталгаажуулахын тулд ажлын нөхцлийн аудит тогтмол хийх
- Аюулгүй ажлын байр бий болгох зорилгоор согтууруулах ундааны талаархи бодлогыг хатуу баримтлан, согтууруулах ундааны хэрэглээг хянаж байх.

#### АЖИЛ ЭРХЛЭЛТ:

- Баталгаажуулах:
  - Барилгын ажлын үед нийт гэрээт гүйцэтгэгчдын ажилчдын 60% нь Монгол ажилчид байх
  - Ашиглалтын үйл ажиллагааны үе шатны 3,500 ажилчны Монгол ажилчдын тоо 10 жилийн дотор 90 хувьд хүрсэн байх
  - Үйлдвэрлэл эхэлснээс хойш 10 жилийн дотор Оюу Толгойд ажиллаж буй Монгол инженерүүдийн тоог 70-аас доошгүй хувьд хүргэсэн байх
- Ажил эрхлэлтийн тэгш боломжийг үргэлжлүүлэн олгох.

#### СУРГАЛТ:

- Дор дурьдсан зүйлстэй болон түүгээр хязгаарлагдахгүйгээр, Монгол Улсын түүхэн дэх хамгийн томд тооцогдох 110 тэрбум төгрөгийн (85 сая ам доллар) хөрөнгө оруулалт бүхий, Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ:
  - Монгол Улсын их, дээд сургуулиудад суралцах оюутны 120 тэтгэлэг, гадаадын их, дээд сургуулиудад суралцах оюутны 30 тэтгэлэг
  - Монгол Улсын ЗГ-тай хамтарсан магистр, докторын зэргийн тэтгэлэгт хөтөлбөр нь Монгол Улсын иргэдэд уул уурхайн инженерийн чиглэлээр голлон боловсрол эзэмшихэд нь туслалцаа үзүүлэх (шаардлага хангах 230 оюутныг магистрантур болон докторантурын сургалтад дэмжлэг үзүүлэх)
  - Монгол Улсын 3,330 иргэнийг техник мэргэжлийн сургалтад хамруулах шинэ хөтөлбөр
- Оюу Толгойн Монгол ажилчдын мэргэжлийн чанарыг байнга сайжруулах зорилгоор Оюу Толгойн дотоодын сургалтын стратеги төлөвлөгөөг боловсруулж, төслийг чадварлаг, туршлагатай ажиллах хүчээр хангаж буйг баталгаажуулах.

#### АЖИЛЧДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР:

- Нууцлалыг хадгалсан санал, гомдлын “Асуудлыг дэвшүүлэн гаргаж - Ярилцах!” системийг бүх ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд зориулан хэрэгжүүлэх.

#### ЦАЛИН:

- Өөрийн ажилчдын дундаж цалинг банк, мэдээллийн технологи болон уул уурхайн салбарын дундаж цалинтай байнга жишиж байх
- Гэрээт ажилчдад цалингийн доод хэмжээнээс багагүй сарын дундаж цалин олгох
- Оюу Толгойн олгож буй цалин нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын шударга, тэгш хуваарилалтын зарчмуудад нийцэж буйг баталагаажуулах.

#### ОРОН СУУЦ:

- Урт хугацааны орон сууцны хангамжийн стратегийг боловсруулж дуусгах хүртэл уурхай дээр түр зуурын орон сууцаар хангах
- Орон сууц болон ажилчдын кемп нь Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандартуудад нийцэж буйг баталгаажуулах.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөлийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Хөдөлмөр эрхлэлтийн менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г [www.ot.mn](http://www.ot.mn) цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.